

**Удирдах ажилтнуудын 01 дүгээр сарын 23-ны өдрийн
шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн биелэлт**

2023 оны 02 дугаар сарын 06

№	Өгөгдсөн үүрэг, даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
1.	2022 оны Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлэг мэдүүлэх үүрэг бүхий албан тушаалтнууд 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор хуулийн хугацаанд баригдахгүй мэдүүлж дуусгах	2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор	Бүх байгууллагын дарга нар	2023 оны Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлэг мэдүүлэх аймгийн Засаг даргын Тамгын газрын эрх бүхий албан тушаалтанд хамаарахгүй 5 байгууллагын 59 албан тушаалтан ХАСХОМ-ийн мэдүүлгээ мэдүүлсэн байна. /Цагдаагийн хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Статистикийн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар/ Аймгийн Засаг даргын Тамгын газрын эрх бүхий албан тушаалтанд хамаарах 21 байгууллагын 125 албан тушаалтан ХАСХОМ мэдүүлэхээс мэдүүлэг гаргасан 96, мэдүүлэг гаргаагүй 28 албан тушаалтан байна. Хэрэгжилт 77.4 хувьтай. Мэдүүлэг дутуу болон гаргаагүй байгууллагууд: Байгаль орчин, аялал жуулчлалын газар-3 Эрүүл мэндийн газар-2 Нэгдсэн эмнэлэг-3 Сүмбэр сум-8 Баянтал сум-1 Шивээговь сум-12 албан тушаалтан дутуу байна.	77.4
2.	Цаг агаар эрс хүйтэрч байгаатай холбоотойгоор сумын Засаг дарга нар малчдын өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцаж, шаардлагатай тохиолдолд зохих журмын дагуу сумын аюулгүйн нөөцөөс өвс, тэжээл олгох ажлыг зохион байгуулах.	2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр	Сумдын Засаг дарга нар	Цаг агаар эрс хүйтэрч байгаатай холбоотойгоор сумдын Засаг дарга нар дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд: Сүмбэр сум: 2023 оны 1 дүгээр сарын 28-29-ний өдөр аймгийн Засаг дарга, Сүмбэр сумын Засаг дарга, 5, 6 дугаар багийн Засаг дарга нар, аймгийн УЗХорооны дарга Б.Мөнхсүх, Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч Б.Хаянхяраваа нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг өвөлжилт хүндэрсэн багуудын малчидтай уулзаж малчин өрхүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж, санал хүсэлтийг хүлээн авч ажилласан. Үүний дагуу аймгийн нөөцөөс 1800 боодол өвсийг 6 дугаар багт татан байршуулсан. Баянтал сум: Сумын аюулгүй нөөцөд өвс 23.5 тн, Тэжээл 14.52 тн байгаагаас сумын Засаг дарга малчдын өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцан өвөлжилт хүндэрсэн нөхцөл байдлыг харгалзан сумын аюулгүйн нөөцөөс 25 өрхөд 2.52 тн өвс олгосон. Шивээговь сум: Өвөлжилтийн байдал хүндэрч байгаатай	90%

				холбогдуулан 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр аюулгүй нөөцөд 250 шуудай буюу 6.2 тн хивэг бэлтгэн нөөцөлсөн. Сумын аюулгүй нөөцөд бэлтгэсэн өвс тэжээлийг малчдад олгох ажлыг зохион байгуулж, мэдээллийг хүргэж байна. 02 дугаар сарын 6-7-ны өдрүүдэд сумын Засаг дарга, багийн Засаг дарга нар малчдын өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцахаар төлөвлөөд байна.	
3.	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны харьяа И–Монгол академиас зохион байгуулах “Цахим үндэстэн Цахим бичиг үсэг тайлагдал”–сургалтад холбогдох албан хаагчдаа оролцуулах	2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 09:00-17:00 цагт /хуваарийн дагуу/	Бүх байгууллага	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны харьяа И–Монгол академиас зохион байгуулах “Цахим үндэстэн Цахим бичиг үсэг тайлагдал”–сургалтад 37 байгууллагын 145 албан хаагчид хамрагдсан. Дараах байгууллагууд оролцоогүй байна. Үүнд: 1. Шивээговь сумын ЗДТГазар 2. Баянтал сумын Соёлын төв 3. Шивээговь сумын Соёлын төв 4. Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар 5. Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Байгууллага нүүж байгаа/ 6. Ус-Ду ОНӨААТҮГазар 7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 0425 дугаар нээлттэй хорих анги 8. Цагдаагийн хэлтэс 9. Онцгой байдлын газар 10. Аймгийн Нэгдсэн эмнэлэг	78.7
4.	Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд орон нутагт ажиллаж, амьдарч буй нийт албан хаагчдын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой нэгдсэн мэдээллийг танилцуулах	2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр	УБХ Бүх байгууллага	2023 он гарснаас хойш манай аймагт нийт 111 хүн шилжиж ирсэн байна. Орон нутагт шилжилт хийлгээгүй 51 албан хаагчаас 3 байгууллагын 26 төрийн албан хаагч дээрх хугацаанд шилжин ирсэн байна. Мөн 4 байгууллагын удирдлага 5 албан хаагчид шилжилт хөдөлгөөн хийлгэх үүрэг чиглэл өгсөн байна. Дээрх мэдээллийг Улсын бүртгэлийн хэлтсийн дарга аймгийн Засаг даргын Орлогч даргад танилцуулсан.	50.9
5.	Цэргийн бүртгэлийн нэгдсэн мэдээллийг танилцуулах	2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр	ЦШ	Цэргийн бүртгэлийн үйл ажиллагааг хугацаанд зохион байгуулсан. Цэргийн бүртгэлийн нэгдсэн мэдээллийг 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр сумдын Засаг даргын Тамгын дарга нараас нэгтгэж авах тул удирдлагуудад танилцуулах бэлтгэж байна.	100%
6.	Нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж иргэдийг татан оролцуулах, байгууллага бүр гадаад	2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр	Сумдын Засаг дарга нар Бүх байгууллага	Нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах ажлын хүрээнд: Сүмбэр сум: Бүх нийтийн их цэвэрлэгээг 2023 оны 02 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр “Сүмбэрийн мэдээ”,	70%

	тохижилтоо сайжруулах			<p>“Хоггүй Сүмбэр” пэйж хуудсуудаар дамжуулан ААНБ, иргэдэд зар мэдээллийг 2 удаагийн давтамжтай түгээсэн. 02 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 14 ААНБ 50 метр талбайн цэвэрлэгээ болон нийтийн эзэмшлийн талбайн хуваарт газрыг цэвэрлэж “Хоггүй Сүмбэр” пэйж хуудсанд тайлагнаж ажилласан байна. 02 дугаар сарын 04-ний өдөр Төвийн 3 баг дээр иргэдийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, 1-р баг тээвэрчдийн байр 45 өрхөөс 6 өрх, багш нарын байр 18 өрхөөс 4 өрх, хорихын 75-ын 5-н давхар 192 өрхөөс 58 өрх цэвэрлэгээнд гарч 2 тонн хог хаягдал, 2-р баг урт, богино дэнжийн 831 өрхөөс 352 өрх, 6-н байшингийн 143 өрхөөс 65 өрх цэвэрлэгээнд гарч 3 тонн хог хаягдал, 3-р баг Баянхошууны 86 өрхөөс 34 өрх, Баянбулагийн 210 өрхөөс 52 өрх цэвэрлэгээнд гарч ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэж 12 тонн хог хаягдлыг ачуулж тээвэрлэсэн.</p> <p>Баянтал сум: 2023 оны 02 дугаар сарын 05-ны өдөр бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулаж, төсвийн 5 байгууллагын 29 албан хаагч, 10 иргэн Лүн, Сүнд, Сансарын эгнээг цэвэрлэн 6.0тн хогийг цэвэрлэсэн.</p> <p>Шивээговь сум: Нийтийн цэвэрлэгээг зохион байгуулаагүй байна.</p>	
Биелэлтийн дундаж хувь				77.8	

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС